



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/12/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Эвиденс аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав
Улаанбаатар хот	Утас: 99057121 Цахим хаяг: info@evidenceaudit.mn
2024 он	Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
	Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
	Аудитор: Т.Болортуяа
	Утас: 99017537 Цахим хаяг: Bolortuya@evidenceaudit.mn
	Аудиторын туслах: М.Отгонням
	Утас: 85222519 Цахим хаяг: Otgonnyam@evidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

Г ХОВД АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗРЫН ДАРГА
О.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2024.02.24 № 1/105
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд байгууллага шуудан холбооны зардлыг 166.6 мянган төгрөгөөр, түлш, халаалтын зардлыг 646.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэл хагас жилийн байдлаар 4 зорилт бүхий 48 арга хэмжээнээс 32 арга хэмжээ 100 хувьтай, 6 арга хэмжээ 90 хувьтай, 10 арга хэмжээ

70 хувьтай хэрэгжиж, дунджаар 93 хувийн гүйцэтгэлтэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Нэг . Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мян. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	796,934.14	601,483.98
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	402,326.04	545,279.91
	Нийт хөрөнгийн дүн	1,199,260.17	1,146,763.89
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,199,260.17	1,146,763.89
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,199,260.17	1,146,763.89
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	702,318.82	1,165,374.40
	Үйл ажиллагааны зардлын дүн	547,658.55	1,222,630.59
	Үйл ажиллагааны үр дүн	154,660.28	(57,256.19)
	Үйл ажиллагааны бус үр дүн	1,567.86	75.00
	Үйл ажиллагааны нийт үр дүн	153,092.41	(57,331.19)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,194,425.27	1,194,425.27
	Тайлант оны үр дүн	-	(47,661.39)
	Эцсийн үлдэгдэл	1,194,425.27	1,146,763.89
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	352,249.71	1,051,727.74
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	358,632.90	1,051,727.74
	Үйл ажиллагааны ЦМГ	(6,383.19)	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	6,383.19	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	714,260.70	680,868.91
	Урсгал зардал	714,260.70	680,868.91
	Хөрөнгийн зардал	-	-
	Эргэж төлөгдөх зээл	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	714,260.70	714,260.70
	Улсын төсвөөс санхүүжих	714,260.70	714,260.70
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих /бусад/	-	-
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	-
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Хоёр . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 10,802.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өглөө.

3.1 Зөвлөмж

3.1.1 Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримт бүрдэл хийж бүртгэлд тусгасан (дутуу Томилолтын) удирдамж тайлан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 заалтад “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөвлөмж хүргүүлэв.

3.1.2 Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Иргэн Ж.Болормаа нэхэмжлэлтэй хэрэгт гэрээ байгуулан ажилласан боловч Ховд аймгийн иргэний хэргийн шүүхийн гарсан шийдвэрийн дагуу харилцагч захиргааны хуулийн дагуу төлөх шийдвэр зардлыг хэн буруутай шийдвэр гаргасан этгээдээс авлага үүсгэх ёстой. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3. “Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зөвлөмж хүргүүлэв.

3.2 Төлбөрийн акт

3.2.1 Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүнсний хувьсгалын төслийн хүрээнд зарцуулах төсвөөс баяр ёслолын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар хувь хүний дансанд даргын тушаалаар мөнгө гарган шилжүүлсэн боловч ажлын тайлан, е баримт анхан шатны дэмжих баримт байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь заалтад Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3. “Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Ховд аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Газар	Хүнсний хувьсгалын төслийн хүрээнд зарцуулах төсвөөс баяр ёслолын үзэсгэлэн худалдаа зохион байгуулахаар хувь хүний дансанд даргын тушаалаар мөнгө гарган шилжүүлсэн боловч ажлын тайлан, е баримт анхан шатны дэмжих баримт байхгүй байна.	1	3,000.0	1	3000				
	Анхан шатны баримт бүрдэл хийж бүртгэлд тусгасан (дутуу Томилолтын) удирдамж тайлан.	1	6,802.4			1	6,802.40		
	Иргэн Ж.Болормаа нэхэмжлэлтэй хэрэгт гэрээ байгуулан ажилласан боловч Ховд аймгийн иргэний хэргийн шүүхийн гарсан шийдвэрийн дагуу харилцагч захиргааны хуулийн дагуу төлөх шийдвэр зардлыг хэн буруутай шийдвэр гаргасан этгээдээс авлага үүсгэх ёстой.	1	1,000.0			1	1,000.00		
		3	10,802.40	1	3000	0	0.00	2	7,802.40

ДӨРӨВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

		Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр							
№	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			